



ӨМНӨГОВЬ АЙМАГ

ОРОН НУТГИЙН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймгийн
2019 оны 4 ДҮГЭЭР сарын мэдээ

Нэг. Удирлага, зохион байгуулалтын хүрээнд

- Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит 7 дугаар хурал 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр хуралдаж цаг үеийн 10 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд Аймгийн ИТХ-ын хуралдааны тов зарлаж, хэлэлцэх асуудлын жагсаалт батлах тухай асуудлыг хэлэлцэн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр АИТХ-ын Төлөөлөгчдийн хурлыг хуралдуулахаар боллоо. Мөн Энэ онд эхийн алдар 1,2 дугаар одонгоор шагнагдах эхчүүдийн нэрс батлах тухай, аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхим ашиглах журам батлах тухай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр батлах тухай, "Орлогод нийцсэн орон сууц" аймгийн дэд хөтөлбөр батлах тухай, Өмнөговь аймгийн "Эрчим хүчний салбарт баримтлах бодлого"-ын баримт бичгийн явцын хэрэгжилттэй танилцах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход санал өгөх тухай, орон нутгийн өмчийн тухай, Төрийн шагналд тодорхойлох тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит 8 дугаар хурал 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж 6 асуудал хэлэлцлээ. Үүнд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 4/3 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ээлжит 8 дугаар хурлын Илтгэл илтгэгчийг батлах тухай, Аймгийн баяр наадмын тов зарлах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон аймгийн ИТХ-ын шагнал хэлэлцэх тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн ИТХ-ын ээлжит 8 дугаар хуралдаан 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 8 дугаар хуралдаан 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 100 хувийн ирцтэйгээр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. "Аймгийн 2019 оны төсвийн тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 7/5 тогтоолын хавсралтуудад өөрчлөлт оруулах тухай
2. Зарим газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, тусгай хамгаалалтаас чөлөөлөх тухай
3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 5/9 тогтоолыг хүчингүй болгох тухай
4. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам батлах тухай

- Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Аймгийн Засаг даргын Тамгын газар 04 дүгээр сарын 24-ний аппаратын хурал хийж 6 асуудал хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. Тус хурлаар:

Иргэдийн дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллүүлж эрүүл мэндийг бэхжүүлэх, эдийн засагт хэмнэлт хийх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах, автозамын түгжрэлийг бууруулах, унадаг дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх, дугуйн соёлыг сурталчлах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газа, Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн газар хамтран төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн аж ахуй нэгж, иргэдийн дунд "Автомашинаас татгалзъя-Ажилдаа дугуйгаар явъя" аяныг 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

- Төсвийн гүйцэтгэлийн мэдээ

Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн 3-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээ болгон хүргүүлсэн. 3 дугаар сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 19.6 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 25.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрч орлогын төлөвлөгөө 128.1 хувийн биелэлттэй буюу 28.1 хувиар давуулан биелүүлсэн байна. Нийт 43 төсөвт байгууллагуудын 2019 оны 3 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан. Орон нутгийн байгууллагуудын 3 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээсэн бөгөөд сумд, орон нутгийн төсвийн байгууллагууд, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 4-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо. Төрийн сангийн нэгжүүдэд хийх дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу 2019 оны эхний төрийн сангийн дотоод хяналтыг Номгон, Хүрмэн, Булган, Мандал-Овоо, Цогт-Овоо, Ханхонгор сумдад хяналт шалгалт явууллаа. Санхүү, төрийн сангийн хэлтсээс аймгийн Татварын хэлтэстэй хамтран “Төрийн сангийн төлбөр тооцоо ба Татварын удирдлагын нэгдсэн системийн сургалт”-ыг аймгийн төвийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, нярвуудад хийж нийт 90 гаруй хүн хамрагдлаа.

- ***Татвар төлөлтийн байдал***

Төсвийн орлогын 3-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулан хүлээн авлаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

- ***Боловсролын чиглэлээр***

Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлыг хангах АЗД-ын 2019 оны 03 дугаартай албан даалгаврыг гаргаж, хэрэгжүүлж байна. Мөн бэлтгэл ажлын хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалтын тандах шалгалтыг 7 хичээлээр зохион байгуулж, 128 төгсөгчийг хамрууллаа. Шалгалтын дүн мэдээнд дүгнэлт хийж, дүгнэлтийн дагуу Боловсрол, соёл, урлагийн газар, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарт үүрэг чиглэл өгч, давтлагын хуваарь гарган, хуваарийн дагуу давтлага хийж байна. Сургуулийн өмнөх боловсролын туслах багшийн “Хүүхэдтэйгээ тоглоцгооё” сургалтыг зохион байгуулж, 150 туслах багшийг хамруулан, мэдлэг боловсролыг нь дээшлүүллээ. Монголын багш нарын 7 дугаар их хуралд аймаг орон нутгаас 18 багш, удирдах ажилтанг оролцууллаа. 22 сургууль, 29 цэцэрлэгээс их хуралд оруулах саналыг авч нэгтгэн 3 чиглэлээр 66 саналыг их хуралд санал болгож орууллаа. “Ирээдүйн эзэд” байгалийн ухааны нэгдмэл олимпиадыг 2019 оны 04 сарын 13-ны өдөр зохион байгууллаа. 13 сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11 дүгээр ангийн 80 сурагч оролцож, байгалийн ухааны төрлийн хичээлээр мэдлэг оюунаараа өрсөлдөн шилдэгүүдээ тодрууллаа. “Тогтвортой хөгжилд-удирдлагын оролцоо” боловсролын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч болох нийт 105 хүнийг хамруулж, боловсролын салбарын бодлого, чиглэл, хүүхдийн эрүүл аюулгүй орчин нөхцөл, хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийж, боловсролын салбарын ололт амжилт, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл, тулгамдсан асуудлаа хэлэлцэж, зөвлөлдлөө.

- ***Эрүүл мэндийн чиглэлээр***

Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар зөвлөн туслах арга зүйн сургалт»-ыг Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд 15 сумын эмч, мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан нарт 4 хоногийн турш зохион байгуулахаар аймгийн НБХ, ЭМГ, БСУГ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна. Мөн нийт 6-12 ангийн хүүхэд, эцэг эхчүүд багш нараас буюу 9000 хүнээс судалгааг авч аймгийн өсвөр үеийн хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг тодорхойлох судалгааг эхлүүлээд байна. Өмнөговь аймгийн алслагдсан сум орон нутагт амьдарч байгаа иргэдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үйлчилгээ үзүүлэгч эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, чадавхийг дээшлүүлэх зорилгоор ЭМЯ, ЭМХТ, АШУҮИС-тай хамтран 4 өдрийн суралтыг зохион байгуулж нийт 10 сумын 50 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрууллаа. Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн салбар, түүний дотор уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Монгол эмнэлэгийн хороотой санамж бичиг байгуулан ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд олон ажлуудаг хамтран хийж хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд “БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн монгол эмнэлэгийн хороонд эхний ээлжинд уламжлалтын 8 эмч,

сувилагч нарыг зүү засал, хануур төөнүүр, саа саажилт, нуруу нугасны гэмтэл, тархинд цус харвалтын дараах нөхөн сэргээлт зэрэг чиглэлээр 10 хоног ажлын байран дээрх сургалтад хамруулсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ханбогд сумын "Сум дундын эмнэлэг" дижитал рентген аппаратаар хангалаа. Ханбогд сумын төдийгүй хөдөлгөөнт хүн ам, алслагдсан нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэх чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монгол улс БНХАУ-ын хооронд дипломат харилцаа байгуулсаны 70 жилийн ой, Улаан загалмайн нийгэмлэгийн түүхт 80 жилийн ойн хүрээнд Өвөр Монголын Өөртөө Засах Ороны Баяннуур аймгийн эмч нартай хамтран 20 гаруй нүдний болор цайх өвчтэй хүмүүсийн эмчилгээ, оношилгоонд хамруулж эрүүлжүүлсэн.

- **Нийгмийн хамгааллын чиглэлээр**

2019 оны 03 сарын 29, 04 сарын 15-нд ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, уул уурхайн компаниудтай хамтран "Ажлын байрны нээлттэй өдөрлөг"-ийг 2 удаа амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 68 аж ахуйн нэгж байгууллага оролцож, 1159 нээлттэй ажлын байр зарлан, 149 иргэнийг шууд ажлын байраар хангалаа. 04 сарын 05-нд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн төсөл болон үндэсний төсөл хөтөлбөрүүдийг танилцуулах арга хэмжээг Хөгжимт жүжгийн театрт зохион байгуулж, төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. Оюутан залуучуудын хөгжлийг дэмжих зорилгоор оюутан залуучуудын дунд АСК тэмцээн, Даланзадгад сум 1 дүгээр багийн "Залуучуудын урлаг спортын наадам", Гэрэлт гудам арга хэмжээний хүрээнд "Summer cover night" арга хэмжээг зохион байгуулж, 400 гаруй залуучуудыг хамрууллаа. Даланзадгад сумын 8 багийн дунд "Хөршийн холбоогоо сайжруулъя" арга хэмжээг зохион байгуулж, хөршийн холбооны 80 гаруй гишүүдийг чадавхжууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 төрийн бус байгууллагын төлөөллийг Улаанбаатар, Багануур дүүрэгт туршлага судлах арга хэмжээнд хамрууллаа.

- **Соёл, спортын чиглэлээр**

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлын хүрээнд: Ахмадын өглөөний дасгал, нийтийн бүжиг арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулсан. Бүх нийтийн өглөөний дасгал арга хэмжээг эдүгээ 8 дахь жилдээ зохион байгуулж байна. Даваа-Баасан гариг хүртэл өглөө бүр 7:00 цагт Ажнай талбайд болох бүх нийтийн өглөөний дасгал 6-р сарын 1 хүртэл зохион байгуулахаар ажиллаж байна.

2. Соёлыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан говь нутгийн соёлын биет бус өвийг хадгалах, хамгаалах түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор язгуур урлагийн бага наадмыг хоёр дахь удаагаа амжилттай зохион байгууллаа. Уг наадам нь соёлын биет бус өвийг уламжлагч Өмнөговь аймгийн харьяат Монгол улсын Ардын жүжигчин Ц.Цэрэндорж, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн П.Байгальжав, Гомбын Оргой нарын нэрэмжит морин хуур, ерөөл магтаал, аялгуут магтаал, уртын дуу зэрэг төрлүүдээр зохион байгуулагдаж байна. Энэ жилийн наадамд 15 сумдын нийт 380 гаруй соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, ардын авьяастанууд оролцуулан амжилттай зохион байгууллаа.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

- **Газар тариалан**

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр, аймгийн ИТХ-ын 2018 оны 6/3 дугаар тогтоолыг үндэслэн Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх аймгийн Засаг Даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөрийн 84 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих” орон нутгийн дэд хөтөлбөрийг боловсруулж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулсан.

- **Мал, аж ахуй**

2018 онд тэмээн сүргээ төлөөр өсгөсөн 15 сумын 1802 малчин өрхөд 62 810 00 /жаран хоёр сая найман зуун арван мянга/ төгрөгийг “Малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас шийдвэрлэн сумдад олголоо.

- **Жижиг, дунд үйлдвэрлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2018 оны 169 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд 2019 оныг “Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил” болгон зарласантай холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, малчид, иргэд олон нийтийг Хөдөө аж ахуй,

үйлдвэржилтийн ажилд идэвх санаачилгатай оролцох, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2019 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жилийн ажлын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор албан даалгавар, жилийн ажилаар сум дүгнэх удирдамжийг боловсруулан батлуулж сумдад хүргүүлсэн. Засгийн газрын 2015 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратегийг үндэслэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2017 оны А/119/А/355 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” хоёрдугаар шатны арга хэмжээний нээлтийн үйл ажиллагааг орон нутгийн хүнс үйлдвэрлэгчид, хоол үйлдвэрлэгчидийг хамруулан аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнсчдийн холбоо хамтран зохион байгуулж ажилласан.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

- Байгаль орчны чиглэлээр

Монголын аялал жуулчлалын холбоо, Байгаль орчин аялал жуулчлалын яамтай хамтран жил бүр зохион байгуулагддаг “Ай Ти Эм Монголиа-2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2019 оны 03 сарын 29-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Уг арга хэмжээнд орон нутгаас аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг жуулчны бааз, зочид буудал, гэр буудал, “Баян заг” төрийн бус байгууллага, Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Даланзадгад сумын ЗДТГ зэрэг 26 аж ахуй нэгж, байгууллага амжилттай оролцсон. Тус арга хэмжээний зардалд 5,0 сая төгрөгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын 2019.03.22-ны А/248 дугаар захирамжаар олгов. Баянзагийн менежментийн төлөвлөгөөний дагуу тогтвортой аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлэх нэгжийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг 2019 оны 02 сарын 20-ны өдрөөс 03 сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд зарласан. Уг хугацаанд нэг ААН материал ирүүлснийг холбогдох ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж шаардлага хангасан байх тул дэмжиж үйл ажиллагааг эхлүүлээд байна. Аймгийн хэмжээнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Байгалиа хамгаалъя” сарын аяныг 2019 оны 04 сарын 15-аас 05 сарын 15 хүртэлх хугацаанд Жууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулж ажиллах төлөвлөгөөг аймгийн ГХУСАЗСЗ /гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл/ -ын даргаар батлуулан ажил эхлүүлээд байна. Уг аяны хүрээнд байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажилладаг мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулах, байгаль орчны зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, хяналт тавих, хохирол тооцох талаар байгаль шинжлэлийн болон хууль зүйн талаар онол, практикийн хосолсон мэдээлэлийг олгох зорилгоор “Хүрээлэн буй орчны журмын эсрэг гэмт хэрэг ба байгаль орчны зөрчлийг бууруулахад талуудын оролцоо сэдэвт сургалт семинар 2019 оны 04 сарын 18-ны өдөр аймгийн НУД-нд зохион байгуулагдаж ХААИС-ийн МДС, Байгаль орчны хяналт, үнэлгээ хөтөлбөрийн хороо, ХСИС-ийн Ахисан шатны сургууль, БОАЖЯ, ЦЕГ-ын мөрдөн байцаах алба, ЕПГ-аас сургалт мэдээллийг өгч орон нутгийн цагдаа, шүүх, прокурор, хилийн цэргийн 0131-р анги зэрэг хууль, хяналтын байгууллагын алба хаагчид болон БОАЖГ, МХГ-ын байгаль орчны хяналтын улсын байцаагчид нийт 60 гаруй албан хаагчид оролцлоо

- Дэд бүтцийн чиглэлээр

Аймгийн Засаг даргын захирамжаар 13 иргэний газрын өмчлөлтэй холбоотой шийдвэр гаргаж, 9 иргэн, хуулийн этгээдэд газрыг шинээр буюу шинэчлэн эзэмшүүлсэн. Цогтцэций сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөл боловсруулах ажлын гэгээг “Скэч” ХХК-тай, Мандал-Овоо сумын Нутгийн удирдлагын ордны барилгын зураг төсөл боловсруулах ажлын гэрээг “Бэст дизайн” ХХК-тай, “Буянт зусланг цахилгаан шугамд холбох ажил”-ын зураг төсөл, төсөв боловсруулах ажлын гэрээг “Итгэлийн хад” ХХК-тай, Даланзадгад сумын “Маанийн хийдийн Жасын барилга”-ын зураг төсөл, төсөв боловсруулах ажлын гэрээг “Нутгийн босго” ХХК-тай тус тус байгуулж ажлыг эхлүүлсэн байна. 2019 оны 04 сарын 25-нд Зарим газрыг орон нутгийн тусгай хамгаалалтаас чөлөөлөх авах тухай асуудлын хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 сарын 04-ны өдрийн 9/13 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан “Нарийн сухайт” орчмын 119035 га /гектар/ талбайгаас “Чухамжаргалан” ХХК-ийн XV-46000024 дугаартай талбайн 144.85 га /гектар/ талбайг ашигт малтмал ашиглах зориулалтаар орон нутгийн тусгай хамгаалалттай газраас чөлөөлөх асуудлыг хэлэлцүүлэн батлуулав. 2019 оны 04 сарын 25-нд

Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг дэвсгэрт орших “Баянбулаг” нэртэй солбицол бүхий 4069.48 га /гектар/ газрыг бичил уурхайн зориулалттайгаар 5 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хэрэгцээнд авах асуудлыг хэлэлцүүлэн батлуулав. Ханбогд сумын нутаг дэвсгэр Оюу толгой уурхайн Улаан шавар, Ундайн элс, Халив элс, Дугатын хяр, мөн “Санчир инженеринг” ХХК-ын Чулуут-2 зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн 2017, 2018 оны уулын ажлын төлөвлөгөөг холбогдох хуулийн дагуу хянан баталгаажууллаа. Эрдэс баялгийн салбарын орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох бодлогын зөвлөмж, шийдлийг тодорхойлох зорилгоор орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хэлэлцүүлэгт 2019 оны 04 сарын 22, 23-нд оролцлоо. Уул уурхайн үр өгөөжийг орон нутагт хүртээх, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчны нөхөн сэргээлт хийх зэрэг уул уурхайн компаниудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилго бүхий “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”- ний хэрэгжилт, үр нөлөөг орон нутгийн бодит туршлага, сургамжид тулгуурлан хэлэлцүүлэг боллоо. Хэлэлцүүлэгт 21 аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, уул уурхайн компаниудын төлөөллүүд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын төлөөлөл, Олон Улсын байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр

Худалдан авах ажиллагааны 2018 оны гүйцэтгэлд ХШҮ хийх ажиллагаа 80-ийн биелэлттэй байна. ХШҮ-ний тогтолцоог бэхжүүлэх, нэгж, ажилтныг чадавхижуулах, ажлын туршлага солилцох арга хэмжээ ЗГХЭГ-т зохион байгуулагдсан бөгөөд аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ажлын туршлага Brainstorm/Сайн туршлага/-аар шалгарсан байна. Уг арга хэмжээний үеэр аймаг орон нутагт ХШҮ-ний тогтолцоог бэхжүүлэх, нэгж, ажилтныг чадавхижуулах талаар 20 минутын видео танилцуулга бэлтгэж сургалтад оролцогчдод тараав. Тус сард Засгийн газрын тогтоол 7, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 11, бүгд 18 шийдвэрийг хүлээн авч эзэнжүүлсэн байна. ЗГХЭГ-аас аймаг, нийслэл, яам, агентлагийн ХШҮ-ний ажилтнуудад зохион байгуулсан “Харилцан суралцах арга зүй” сэдэвт сургалтыг 5 сард өөрийн аймагт зохион байгуулахаар төлөвлөгөө, удирдамжийг боловсруулаад байна

Найм. Батлан хамгаалах чиглэлээр

Сумдад батлан хамгаалах чиглэлээр хөтлөгдөж буй болон нууц баримт бичгийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар сумдын ЗДТГ-ын дарга нарт зөвлөгөө өгч ажиллав. Зарим сумдыг дайчилгааны бэлэн байдлын дохиогоор ажиллуулан 2019 онд цэргийн чухал мэргэжил олгох сургалтад хамрагдсан бэлтгэл үүрэгтнийг мэргэжлийн дагуу бүртгэх, оногдуулан данслах, онц болон дайны үед эдийн засаг, нийгмийн өндөр ач холбогдол бүхий хамгаалалтад авах шаардлагатай объектын хамгаалалтыг зохион байгуулах тооцоо гаргуулан, дохиогоор ажилласан нотломж бичүүлэв. Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай инженер, техникийн мэргэжил бүхий иргэдийн судалгааг гаргаж БХЯ-ны СБТГ-т хүргүүлэв. Аймгийн Засаг даргын 2019 оны а/349 дүгээр захирамжаар 2019 оны 04 дүгээр сарын 13-21-ний өдрүүдэд Баяндалай, Ноён, Гурвантэс, Сэврэй, Булган, Мандал-Овоо, Цогт-Овоо, Даланзадгад сумын 1,3,5,7 дугаар багуудад цэрэг татлагын ажлыг зохион байгуулж явууллаа. Батлан хамгаалахын сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай 2018 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3.4 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны н/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн шинээр бэлтгэх сургалтыг Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатайгаар хээрийн байрлалд зохион байгуулан явуулж тайланг Батлан хамгаалах яаманд хүргүүлэв. Халх голын бүтээлч аяны удирдамжийн хуваарийн дагуу аяны дарцаг дэвтрийг 4 чиглэлийн 16 байгууллагад аялуулан, аяны хүрээнд төрөл бүрийн уралдаан тэмцээн ажлуудыг хэрэгжүүлэн, олон нийтийн хэрэгслээр сурталчилан ажиллаж байна.

СУМДЫН МЭДЭЭ

БАЯНДАЛАЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 3-р хурлыг хуралдуулж 4 асуудал хэлэлцсэн бөгөөд 1. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд “Ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах” чиглэл батлан байгууллага, албан хаагчдад хүргүүлэв. 2.Гурван-Мөнх ОНӨҮГ-ийн 2018 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг авч хэлэлцсэн байна. Сумын Засаг даргын А захирамж-5, Б захирамж-3 нийт 8 захирамж гаргасан. ЗДТГазрын даргын А тушаал-5, Б тушаал-1 нийт 6 тушаал гаргасан байна.

Хоёр.Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Баян багийн 2019 оны 1 дүгээр улирлын иргэдийн Нийтийн Хурал багийн төв дээр амжилттай болсон байна. Хурлаар багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн Засаг дарга нарын 2018 онд хийсэн ажлын тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгсөн бол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас өнгөрсөн онд сум орон нутгийн хэмжээнд хийгдсэн бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт, олон нийтийг хамарсан томоохон ажлууд, 2019 онд хийгдэх ажлынхаа мэдээллийг өгч санал бодлыг нь сонслоо. Мөн ЗДТГазрын мэргэжилтнүүд ЭМТөв, 13-р Цэцэрлэг зэрэг байгууллагуудаас шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар болон бусад чиглэлээр мэдээ мэдээлэл өгч ажиллалаа. Эрүүл мэндийн төвөөс малчдыг үзлэг шинжилгээнд хамруулан зөвлөгөө өглөө. 2019 оны цэрэг татлагын ажил явагдаж 51 иргэн хамрагдлаа. Дотуур байрны хүүхдүүдэд хамтарсан баг ба хүүхдийн эрхийн зарим чиг хандлага сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад 26 хүүхэд хамрагдлаа. Тус сумын уугуул ахмад багш Ц.Раднаа дэлхийн аварга шалгаруулах ахмад мастеруудын хөнгөн атлетикийн тэмцээний 400 м төрөлд 85 насандаа алтан медаль авч дэлхийн аварга хэмээх хүндтэй цолыг хүртлээ.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Баяндалай сумын хэмжээнд халамжийн сангийн тэтгэвэр 52 иргэнд 9.391.800 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 50 иргэнд 5.289.981 төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж 9 эхэд 400,000 төгрөг, Цалинтай ээж 116 эхэд 5.950.000 төгрөг, Алдарт эхийн одон 4 иргэнд 600000 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 3 иргэнд 60000 төгрөг нийт 234 иргэнд 21.961,789 төгрөгийн олголтыг үүсгэн ХХҮГазарт хүргүүлсэн. Шинээр төрсөн 3 хүүхдийн анхан шатны материалыг хүлээн авч хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулахаар өргөдлийг дээд шатны байгууллагад хүргүүлсэн. ӨАТС-нд хамрагдаагүй 2 өрхөөс судалгааг авсан. Шинээр ажил хайгч буй 2 иргэнийг бүртгэж, бүртгэлтэй байсан 4 иргэний бүртгэлийг сэргээж , 4 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Говийн оюу сангаас хэрэгжүүлсэн Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд 2017 онд хамрагдсан Х.Цэдэвсүрэн “Угалз бүрээс”, С.Ундрал “Шинэ амт” , Ж.Наранцаиралт “Эсгий урлал” төслийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн. 2019 онд хэрэгжих төсөл хөтөлбөрийг мэдээллийн самбар болон багийн ИНХ болон иргэдэд цаг тухай бүрт нь мэдээлэл хүргэж ажиллаж байна. Аж ахуй нэгжийн сургалтад хамрагдах хүсэлттэй 14 иргэний судалгааг гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлсэн.Багийн ИНХ-аар иргэдэд Халамжийн тухай хууль болон 2019 онд хэрэгжих төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг хүргэж ажилласан. Багийн ИНХ-аар 76 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан. Төхөм болон Баян багийн Иргэдийн Нийтийн хурал 03 сарын 25-26 ний өдрүүдэд багийн төвд зохион байгуулагдсан бөгөөд уг хурлуудаар нийт 76 иргэнд цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг өгч ажиллалаа. Гурван багийн ИНХурлаар явж ТУНСистемийн талаар сургалтыг зохион байгуулж ажиллалсан.Тус сургалтанд 2 багийн 76 иргэн оролцсон. Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас энэ жил Баяндалай суманд 30.0 мянган долларын санхүүжилт хийгдэхээр гэрээ байгууллаа. Мөн тус сангийн танилцуулга хийгдэж өнгөрсөн жилийн санхүүжилтээр хийгдсэн уурын зуухны халаалтын тогоо суурилуулах ажлын гүйцэтгэл болон Гурван мөнх ОНӨААТУҮГ-ын тохижилт үйлчилгээний талаар мэдээлэл хийж дурсгалын зүйл гардууллаа. Оюутан залуучуудынхаа уулзалтыг зохион байгуулан тэднийхээ санал бодлыг сонсч сум орон нутагтаа хийж хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, бусад ажлынхаа талаар мэдээлэл өгч цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллах үүднээс нэгдсэн зохион байгуулалтад оруулан оюутны зөвлөлийг шинээр байгууллаа. Мөн оюутнуудынхаа дунд сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээн уралдаан зохион байгууллаа.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Халх голын 80 жилийн ойн тохиолдуулан “Халх гол”-ын туг аялуулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.Туг аялах арга хэмжээнд сумын төвийн албан байгууллага, аж ахуй нэгж

бүгд хамрагдан оролцож иргэдийн дунд олон талт арга хэмжээг зохион явуулна. Туг аялуулах арга хэмжээг Цагдаагийн байгууллага эхлүүлэн зохион байгуулж 96 иргэнийг хамруулан ажиллаж дараагийн байгууллага, Чойнидын нэрэмжит Ерөнхий болосролын бүрэн дунд сургуульд шилжүүлэн өгсөн байна. 2018 оны 3,4, 2019 оны 1-р улирлын тогтоолын эмхэтгэл хийж багийн ИНХ-ын дарга, тэргүүлэгчдэд гарын авлага материал тараасан. Багуудын 1-р улирлын хурлыг Баян баг, Наран багт Зөөлөнд, Төхөмд тус тус хэсэгчилсэн байдлаар хуралдуулж 166 өрхийн малчид хамрагдсан. Багийн ИНХ-аар “Гэр кемп ажиллуулах журам”, өвөлжөө хаваржааны зориулалтаар газар олгох тухай журмуудыг 166 иргэнд сурталчилсан. Сумын төвд мэдээллийн цагийн хуваарийн дагуу ХААН банк, ЕБС, Төрийн банк, гэрлийн байцаагч зэрэг байгууллагууд иргэдэд мэдээлэл хийж 83 иргэн оролцсон. 64 иргэнээс давхардсан тоогоор 82 санал ирснийг байгууллага бүрт Хурлын даргын албан тоот / №23,24,25/-оор эзэнжүүлсэн.

Тав. Багт хийгдсэн ажил

Цэрэг татлагын зарлан дуудах хуудсыг 18-28 насны цэрэг 2 дугаар зэргийн үүрэгтэнд тараан иргэдээ бүрэн хамруулан ажиллаа. Мөн 55–аас дээш насны иргэдийн судалгааг гарган ахмадын хороонд өглөө. Багийн судалгаа танилцуулга хийж аймгийн 59 багийн номонд оруулахаар судалгааг бэлтгэн гаргалаа.

БАЯН-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Засаг даргын Тамгын газрын даргын А Тушаал 4 гарсан байна. Үүнд: Үр дүнгийн урамшуулал олгох тухай, Ажил хүлээлцэх комисс томилох тухай, Ажил хүлээлцэх комисс томилох тухай, Ажил хүлээлцэх комисс томилох тухай, Засаг даргын Тамгын газрын даргын Б Тушаал 6 гарсан байна. Үүнд: М.Наранчимэгийг ажлаас чөлөөлөх тухай, О.Алтанцэцэгийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай, Б.Өнөрцэцэгийг ажлаас чөлөөлөх тухай, М.Наранчимэгийг ажилд түр хугацаагаар томилох тухай, Ц.Отгонжаргалыг ажлаас чөлөөлөх тухай, А.Нандин-Эрдэнийг ажилд түр хугацаагаар томилох тухай, Засаг даргын А Захирамж 5 гарсан байна. Үүнд: Хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх тухай, Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай, Хөрөнгө зарцуулах тухай, Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай, Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Нүүрс тээврийн авто замын дагуух үйлчилгээний цэгүүдэд сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан хяналт шинжилгээ хийж, зөрчил дутагдалтай байгууллага аж ахуйн нэгж, хувь иргэдэд хугацаатай албан үүрэг өгч ажиллалаа.Татварын албанаас Татварын удирдлагын нэгдсэн системийн талаар нийт 80 иргэнд сургалт зохион байгуулсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Монгол Улсын ардын жүжигчин Ц.Цэрэндорж сумынхаа эрүүл мэндийн төвд мод тарих өдрөөр мод суулгаж модны үрсэлгээ өгөв. Сумын төвийн гарах орох чиглэлд 5 ширхэг өндөр хүчин чадлын камер суурилууллаа. 9-р ангийн сурагчдаа хилийн сумангуудтай танилцуулж эх орноо хайрлан хамгаалах эх оронч үзэл төлөвлүүлэх сургалтыг хилийн суман дээрээ зохион байгууллаа. Халх голын ялалтын 80 жилийн ойг тэмдэглэх нээлтээ хилийн бүдүүний модны суман дээр хийлээ. Оюу толгой ХХК-ны хангамжийн хэлтэстэй хамтран орон нутгийн бизнес эрхлэгчдийн уулзалтыг зохион байгуулж сумынхаа бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийлгэлээ. ХААН банкн дээр ХУР мэдээллийн системээр үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлж эхэллээ. Татварын орлого бүрдүүлэлт: Орон нутгийн орлогын төлөвлөгөө 21813,2 мян/төг төвлөрүүлэхээс орсон орлого-94700,6 буюу 434,1 хувьтай хэрэгжиж байна. Аймагт төвлөрүүлэх орлого: Төлөвлөгөө 48624,8 мян/төг төвлөрүүлэхээс орсон орлого 79177,7 буюу 162,8 хувь, Улсын төсөвт бүрдүүлэх: Төлөвлөгөө 7645,0 мян.төг төвлөрүүлэхээс орсон орлого 11062,7 буюу 144,7 хувь гүйцэтгэлтэй. Багийн иргэд нийтийн хурлаар Налих-60, Могойт-90,Харзаг-70 нийт-220 малчдад “Малын эрүүл мэндийн тухай” хуулийг мэдээлэл хийв. Сумын төвийн дэлгүүр ААН-үүдэд” Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох

тухай “189 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Гялгар уутны хэрэглээ багасган, даавуун уугаа хэрэглээ” гэсэн урааг байгууллагуудаар Байгаль хамгаалагч, Байгаль орчны мэргэжилтний хамт явж танилцуулан 16 ш гарын авлага тараасан. Иргэдийн төлөөлөгчдийн зөвлөл хуралдан Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний талаар албан байгууллагуудаар явж танилцлаа. ХХААГ-г хүлэмжийн блонк 5 ш захиалан авсан. ХХАА-н үйлдвэржилтийн жилийн хүрээнд малын эмч, хөдөө аж ахуйн мэргэжилтний сургалтанд хамрагдав. Газар тариалангийн сургалтанд С.Отгонцэвээн, Б.Саранчимэг, Г.Балчинханд, Оюунчулуун, Б.Сарангэрэл нар сургалтад хамрагдав.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар Малчин өрхүүдийнхээ хаваржилтийн байдалтай танилцаж Налих, Могойт багийн айл өрхүүдээр явж төрийн үйлчилгээг хүргэлээ. Халх голын ялалтын 80 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны нээлтээ хилийн 0131-р ангийн Бүдүүн модны застав дээр очиж хийлээ.

Тав. Багт хийгдсэн ажил

2018 онд аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөсөн гүн өрмийн худгуудаа Эрхэм сүлд ХХК Харзаг багийн малчин Р.Баярсайхан, Могойт багийн малчин Г.Ноов нарынд гаргалаа. Мал төллөлт, төл бойжилтийн мэдээгээ цаг тухай бүрт нь авч гарган мэдээлж байна. Багийн малчин өрхүүдээр сумын Засаг даргын хамтаар явуулын үйлчилгээ үзүүлээ.

БУЛГАН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Засаг дарга нь 04 дүгээр сарын байдлаар Төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай 1, Орон нутгийн хөгжлийн сангийн комисс томилох тухай 1, 2019 оны тээврийн хэрэгслийн техник хяналтын явуулын үзлэг зохион байгуулах тухай 1, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг түших хариуцах албан хаагчдыг томилох тухай 1, Салбар комисс томилох тухай 1, Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах тухай 1, Ажлын хэсэг байгуулах тухай 1 нийт 7 захирамж гаргасан. Тамгын газрын дарга нь 04 дүгээр сарын байдлаар Өргөдөл, гомдол шийдвэрлэх журам батлах тухай 1, Журам батлах тухай 1, Комисс томилох тухай 1, Архивын дүрэм батлах тухай 1, Байгууллагын баримт бичгийг нягтлан шалгах комиссын ажиллах журам батлах тухай 1 нийт 5 тушаал гаргасан.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

ЭМГ, АШУҮИС-аас зохион байгуулсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сургалтад их эмч Ц.Нармандах, багийн эмч Д.Сосорбурам, сувилагч Ө.Наранчимэг, С.Цэндсүрэн нар 2019 оны 04 дүгээр сарын 12 ны өдөр хамрагдсан. 3 сарын 20-ноос эхлэн гадна талбайн тохижилт, саад, цэцэрлэг, цэцгийн мандал хийх зэрэг бүтээн байгуулалтын ажлууд өрнөж хийгдэх талаар ярьж хэлэлцлээ. Аймгийн Засаг дарга Н.Наранбаатар “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн төслөөр хийгдсэн ажлаа газар дээр нь үзэж ЕБСургууль, цэцэрлэгийн төслийн үйл ажиллагаатай танилцаж иргэд хөдөлмөрчидтэй уулзалт хийлээ.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Эрүүл мэндийн төвийн Эмчийн үзлэгт 210 хүнийг хамруулсан. Түргэн тусламжийн дуудлага 4 ирж тусламжийг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлсэн. Товлолт дархлаажуулалтын вакцинд 19 хүүхдийг хамруулаад байна. Нийт 26 жирэмсэн эхийг хянаж байна. Сумын төсөвт байгууллагууд соёлыг дэмжих жилийн нээлтэд зориулж зохион байгуулагдсан спорт, урлагийн арга хэмжээнд хамт олноороо идэвхтэй оролцож, парад жагсаалд үндэсний өв уламжлалаа харуулсан байдлаар хувцаслаж жагслаа. Улсын бүртгэлийн хэлтсийн байцаагч нь 04 дүгээр сарын байдлаар төрсний гэрчилгээ 4, Шинээр үнэмлэх авсан 10, Дахин иргэний үнэмлэх захиалсан 2, Иргэний үнэмлэхний хугацааны сунгалт 2, Шилжин ирсэн 1 тус тус бүртгэсэн. Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн нь халамжийн тэтгэвэрт 46 - н иргэнд 7886320 мянган төгрөг, жирэмсэн нярай 21 иргэнд 840.0 мянган төгрөг, ахмад дайчин 1 иргэнд 200000 мянган төгрөг, 0-3насны хүүхэд асрагч 96 иргэнд 4758.3 мянган

төгрөг олгоод байна. Нийгмийн даатгалын байцаагч нь нийт 19, ААНБайгууллагаас 16 ААНБайгууллага нь 15 946 755.95 төгрөгийн шимтгэл төлсөн. Нийт 114 Сайн дурийн даатгуулагчаас 32 даатгуулагч 3 988 474 төгрөгийн шимтгэл төлжээ. Нийт 275 тэтгэвэр авагчид 91 795 891 төгрөгийн тэтгэвэр олгогджээ. Төрийн банкаар 210 тэтгэвэр, ХААН банкаар 65 тэтгэвэр авагч байна. Үүнээс шинээр тахир дутуугийн тэтгэвэр авагч 1 иргэн, өндөр насны тэтгэврийн нэмэгдэл 1 иргэн, групп сунгуулж ирсэн 2 иргэн, шилжиж явсан 1 иргэн тус тус тэтгэвэр авсан байна. Ажилгүйдлийн даатгалын сангаас 1 даатгуулагч 524 523 төгрөгийн тэтгэмж авсан. Оршуулгын тэтгэмж 1 иргэнд 1 000 000 төгрөг олгосон байна. Эрүүл мэндийн даатгалд 37 даатгуулагч 876 079 төгрөгийн шимтгэл төлсөн.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

- Ерөнхий боловсролын сургуулийн хамт олон Өмнөговь аймгийн хамтын ажиллагааны хүрээнд хамт олноороо ӨМӨЗОрны Баяннуур аймгийн Халиут хотын 2 сургуулиар орж танилцаж туршлага судлаад ирлээ. Англи хэлний онлайн сургалтын багш Т.Ундрахсайхан АНУ-д суугаа төслийн багштайгаа төсөлд хамрагдсан 4-н сурагчийн хамт онлайнгаар шууд холбогдон ярилцлаганд орлоо.

Тав. Багт хийгдсэн ажил

Дэн баг нь 04 дүгээр сарын байдлаар малчдынхаа мал төллөлт, хаваржилтын байдалтай танилцаж багийн малчин өрхүүдээр сумын Засаг дарга, холбогдох мэргэжилтэнтэй хамтран нийт 189 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулан мэдээлэл сурталчилгаа хийж ажиллаа. Сумын төвийн баг нь газар тариалан эрхлэгчдийн хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 14:00 цагт сумын соёлын төвд хийсэн.

ГУРВАНТЭС СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын Засаг даргаас “А” захирамж 16, Засаг даргын Тамгын газрын даргын “А” Тушаал 4, “Б” тушаал тус бүр 4 гарсан байна.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Овоотын Цэргийн ангид Гурвантэс суманд шинээр байгуулагдаж байгаа Бага-Овоо буюу 5 дугаар баг нь багийн тргэдийн Нийтийн Анхдугаар Хуралдаан хийж багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга болон Тэргүүлэгчид Багийн засаг даргаа сонгосон. ЗДТГазраас “Халх голын 80 жил” бүтээлч аяны тугийг 28 дугаар цэцэрлэгт хүлээлгэн өгч 7 хоногийн турш ажиллах чиглэлийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулж энэхүү арга хэмжээнд нийт Хамт олон 14 хүн, Эцэг эх 105, Хүүхэд 110, Иргэд 102, нийт 331 хүн хамрагдсан. Өмнөговь аймгийн нийт туслах багш нарын Тоглонгоо суралцах арга зүй сургалтад 28 дугаар цэцэрлэгээс 4 туслах багш оролцсон. ЗДТГазраас “Тайван жагсаал” Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу Уриан дор” бүх албан байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. ЗТГазар ИТХурал “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ӨДӨРЛӨГ ЗАРЛАЖ нийт 12 уул уурхай эрхэлж буй аж ахуйн нэгжүүд ирж ажлын байр зарлаж 22 иргэнийг шууд ажлын байртай болгосон.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр Төрийн албан хаагчдаа сургалт зохион байгуулсан. 2019 оны 1-р Ээлжийн цэрэг татлага болсон. Иргэнд төвтэй төрийн үйлчилгээний жилийн нээлтийн арга хэмжээ болсон. Төрийн банк Сумын бүх Төсвийн байгууллагуудын дунд Буухиа тэмцээн, Теннис, Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж нийт 40гаруй хүн хамрагдсан. Хаан банк 3vs3 Сагсан бөмбөгийн тэмцээн ТТБ-ллага болон иргэд, Уул уурхайн компаниудын дунд зохион байгуулж нийт 100 гаруй хүн хамрагдсан. Нийтийн бүжиг зохион байгуулж нийт 78 хүн хамрагдсан. Өмнөговь аймгийн Өмнөд бүсийн Цахилгаан Түгээх Станцаас мэргэжилтнүүд ирж уулзалт хийсэн. Өмнөговь

аймгийн Байгаль орчины Баруун бүсийн Усны дэвжээ тэмцээн зохион байгуулагдаж нийт 90 гаруй хүн хамрагдаж оролцсон. Уяачдын холбооны Хурал болсон нийт 46 хүн хамрагдсан.

Дөрөв. Багт хийгдсэн ажил

2019 оны 04 сарын 06-наас 04 сарын 14-нийн хүртэл хугацаанд малчдын хаваржилтын байдалтай танилцах, төрийн үйлчилгээг малчдад хүргэх, мэдээ мэдээлэл солилцох зэрэг ажлаар ажлын хэсэг гарч ажиллав.

ДАЛАНЗАДГАД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

ИТХ-ын Тэргүүлэгчдийн 07 дугаар хурлаас гарсан шийдвэр: Хөршийн хяналтын хөтөлбөр батлах тухай /Тогтоол №60/, Төрийн дээд шагналд иргэдийг тодорхойлох тухай Үүнд: “Алтан гадас одон”-1, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-2 “Цэргийн гавьяаны одон”-2 тус тус шагнахаар шийдвэрлэсэн. Сумын Засаг даргын А захирамж 28, Тамгын газрын даргын А тушаал 15, Б тушаал 5 тус тус гарсан байна. Даланзадгад сумын Засаг дарга болон Тамгын газарт 33 санал хүсэлт өргөдөл ирснээс 12 өргөдөл гомдлыг шийдвэрлэж хаасан, 21 өргөдөл хугацаандаа явж байна. 2019 оны 04 сард Даланзадгад сумын ЗДТГазарт 177 албан бичиг хүлээн авснаас 67 бичиг нь хариутай. Хариутай бичгийг заагдсан хугацаанд шийдвэрлэж ажиллаа. Мөн энэ сард Засаг дарга болон Тамгын газраас 139 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Хоёр.Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Байгууллагын шуурхай хурлыг 3 удаа хуралдаж өнгөрсөн 7 хоногт хийсэн ажил болон ирэх 7 хоногт хийх ажлын хүрээнд ярилцаж, цаг үеийн ажилд идэвхтэй оролцох, зохион байгуулсан ажлын тухай, иргэдэд үйлчлэх чиглэлийн талаар ярилцаж, үүрэг чиглэл өгч ажилласан. Өмнөговь аймгийн Архивын тасаг Архивын Ерөнхий газартай хамтран зохион байгуулсан “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх нь” сэдэвт сургалтанд Архив, бичиг хэргийн эрхлэгч хамрагдлаа. Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх болон төсөл арга хэмжээг эрэмбэлэх сургалтад Ерөнхий нягтлан бодогч болон Дэд бүтэц хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нар хамрагдлаа. Өмнөговь аймгийн Статистикийн газраас Хүн ам орон сууцны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд “Өрхийн дэвтэр хэрхэн бөглөх” талаарх заавар зөвлөгөөний сургалтад 8 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд хамрагдлаа. Мал эмнэлгийн ерөнхий газар, Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх TCP/MON/3701/ төслөөс Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч, эмч нарт зориулсан "Халдварт өвчний дэгдэлтийн судалгаа" сэдэвт сургалтад Мал эмнэлгийн тасгийн дарга хамрагдлаа. Даланзадгад сумын Засаг даргатай 8 багийн Засаг дарга болон Нийгмийн ажилтан нар нууцлалын гэрээг байгуулж хамтарсан багийг чадваржуулах сургалтад хамрагдлаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Соёлын жилийн нээлтэд сумын ЗДТГ-ын албан хаагчид болон 8 багийн 260 гаруй иргэд соёл уламжлалаа илэрхийлсэн үзүүлбэртэй оролцож Их-Уулын 6 дугаар багийн “Улаан гэр” үзүүлбэр 1-р байр эзэллээ. Биеийн тамир спортын төрөлжсөн сургалттай 7-р сургуульд гадаад хэлний лингафоны кабинетыг иж бүрэн тохижуулан хүлээлгэн өглөө. Ерөнхий боловсролын 6 сургууль 100% лингафоны танхимтай боллоо. Сумын Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нартай “Хамтран ажиллах гэрээ” байгууллаа. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ИТХ, ЗДТГазар, Хотын захирагчийн ажлын алба, багийн Иргэдийн Нийтийн Хурлын хамт олон Даланзадгад сумын ИТХ, ЗДТГазар, Хотын захирагчийн ажлын алба, багийн Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа. Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн 80 жилийн ойг тохиолдуулан бүтээлч ажлыг эрчимжүүлэх зорилгоор 21 хоногийн хугацаатай ”Хүмүүнлэг үйлсэд иргэн таны оролцоо“ аяныг 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл зохион байгуулахаар Даланзадгад сумын Улаан загалмайн анхан шатны хорооноос эхлүүлсэн. Даланзадгад сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагчийн ивээл дор сурагчдын спортын авьяас

чадварыг нээн илрүүлэх, хамтач, нөхөрсөг, уур амьсгалыг бүрдүүлж, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулдаг "НАЙДВАР ЛИГ-2019" өсвөрийн сагсан бөмбөгийн тэмцээн ахлах, дунд, бага насны ангиллаар амжилттай зохион байгуулагдаж шагналаа гардууллаа. Даланзадгад сумын зорилтот бүлгийн 80 өрхийн иргэдийг элэгний ВС вирусийн шинжилгээнд хамруулах ажлыг Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгууллаа. Төлчин хүүхэд 2019 оны үйл ажиллагааны хүрээнд 13 малчин өрхөд 26 хүүхэд тусалж мал маллах арга ухаанд суралцсан байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Шөвөг ярын тарилга”-ыг 4390 төлд тарьсан байна. Паразитын арга хэмжээ боловсруулалтад 5100 мал, туулгалтанд 60 нохой, 320 мал хамрууллаа. 2 малчин өрхийн 450м2 малын хашаан талбайг ариутгасан байна. Мал эмнэлгийн үзлэгт 214 тэмээ, 49 адуу, 210 үхэр, 6460 хонь, 10280 ямаа, 5400 төл малыг хамрууллаа. Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Монгол цэргийн баярын төлөвлөгөө гарган 14 ажлыг зохион байгуулж 1400 гаруй иргэнийг хамруулан оролцууллаа. Нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад 24 иргэнийг оролцуулж хяналтыг тоог бүрэн биелүүллээ. Улс орон даяар зарлагддаг газар хөдлөлтийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор Даланзадгад сумын Онцгой комисс, Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 99-н албан хаагч, аврагчдыг жагсааж бэлэн байдлын үзлэгт хамрууллаа. Гал унтраах 21 дүгээр ангитай хамтран “Галын тактикийн сургууль”-ийг зохион байгуулж, 16 байгууллагын 286 албан хаагч оролцлоо. 2019 оны Худалдан авах авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас “Сумын гэр хорооллын гэрэлтүүлгийн зураг төсөв боловсруулах”, “Даланзадгад сумын услалтын системийг засварлаж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх”, “Иргэний танхимын хөгжим, апартур, эд хогшлыг шинэчлэх”, “Соёл амралтын хүрээлэнд гүн өрмийн худаг гаргах” ажлуудын тендерийг цахимаар зохион байгууллаа. “Соёл амралтын хүрээлэнгийн ДП дэд өртөөг солих”, “Тамгын газрын 2,3 давхрын засвар”-ын ажлуудын техникийн комисс ажиллан ажлыг хүлээн авлаа. “Даланзадгад сумын гэр хорооллын гэрэлтүүлгийн ажил”-ыг хийж гүйцэтгүүлэхээр Номин Ендэрт ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүллээ. Мод үржүүлгийн 80 га талбайд аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоолын дагуу хайлаасны баяр, бүх нийтээр мод тарих өдрийн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд УЦУОШГазар, БОАЖГазар, АӨГСГЗахиргаа, ЗААлбаны ойн ангийн ажилчид сум дундын ойн ангийн нийт 80 гаруй албан хаагчид хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж 3,2 тн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлээ.

Даланзадгад сумын төсвийн орлогын төлөвлөгөө 688720,9 мян.төгрөг гүйцэтгэл 520546,8 мян.төгрөг болж 75,6 хувь биелсэн, өөрийн орлогын төлөвлөгөө 2500,3 мян.төгрөг, гүйцэтгэл 5377,0 мян.төгрөг 239,1 хувьтай байна

Дөрөв. Багт хийгдсэн ажил

Халх голын 80 жилийн ойн ажлын хүрээнд багийн ахмад дайчидтай уулзалт зохион байгууллаа. “Өнгө нэмье” залуучуудын анхдугаар чуулга уулзалтыг зохион байгуулж нийт 150 гаруй залуучууд оролцлоо. Улаанбаатар хотод Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяагийн урилгаар “Дуулах өдөр дуун цэнгүүн”-д 40 ахмад оролцлоо. Хан-Уулын 2 дугаар багийн 42 иргэнд ВС вирусийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтыг Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгууллаа.

МАНДАЛ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын ИТХ-н болон Тэргүүлэгчдийн тогтоол 1. /Алдарт эхийн одонд тодорхойлох тухай/ Сумын Засаг даргын захирамж 13./Ажлаас чөлөөлөх тухай. Албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах тухай, Ус ашиглуулах зөвшөөрөл олгох тухай, Сумын тооллогын комисс, багийн тооллогын түр товчоо байгуулах тухай, Засаг даргын нөөц сангаас хөрөнгө зарцуулах тухай, ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын гэрээ байгуулж санхүүжилт олгох тухай, Хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх тухай, Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай, Ажил хүлээлцэх комисс байгуулах тухай, Цэрэг татлагын комисс байгуулах тухай, Дагалдах мөнгөн шагнал олгох тухай, ЗД-н нөөц сангаас хөрөнгө зарцуулах тухай/ Тамгын газрын даргын тушаал 10. /Төрийн

алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай, Ажил хүлээлцэх комисс байгуулах тухай 3, Хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай 3, Хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай, Төрийн албан хаагчийг ажилд томилох тухай

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 4, албан байгууллагын дарга эрхлэгчдийн хурал цуглааныг 3 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар ярилцаж шийдвэрлэв. Дотоодын сургалт зохион байгуулах тухай, Гамшгийн дохиогоор ажиллах тухай, Авилгатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний тухай, Тогтвортой амьжиргаа-3 төслийн сургалтад 10 албан хаагчийг хамруулах тухай, Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн төлбөрийн барагдуулах тухай, Хүний нөөцийн судалгаа гаргах тухай, Цэрэг татлагын арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах тухай, зарлан дуудах хуудас тараах тухай, Говийн оюу ХДС-н квотын гэрээ байгуулах тухай, Хог хаягдлын тухай хуулийн хүрээнд гарч буй журмуудын төсөлд санал хүргүүлэх тухай, Соёлыг дэмжих жилийн нээлт зохион байгуулах тухай, Халх голын ялалтын 80 жилийн ой угтсан аян зохион байгуулах тухай.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Дотоодын сургалтын төлөвлөгөөний дагуу Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албаны шинэчлэгдсэн хууль журмууд, Орон нутагт төрийн захиргааны байгууллага үүсч хөгжсөн түүх, Нийгмийн даатгалын хуулийн шинэчлэл, гэр бүлийн харилцаа сэдвээр 3 удаа сургалт зохион байгуулагдаж нийт 54 албан хаагч хамрагдав. Сургалтыг 2 албан хаагч хамтран дүрс бичлэг, зураг үзүүлэх, харилцан ярилцах зэргээр зохион байгуулсан нь сонирхолтой үр өгөөжтэй сургалт болов.Гамшгийн дохиогоор дадлага сургуулилт хийж, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг шалгаж хангуулав. Говийн оюу ХДС-н квотын гэрээ байгуулагдав. Соёлыг дэмжих жилийн нээлтийн арга хэмжээг бүх байгууллага, ААН-г хамруулан өргөн дэлгэр зохион байгуулав. Халх голын ялалтын 80 жилийн ойн нэрэмжит “Тусгаар тогтнол, түүхэн уламжлал, хөгжил дэвшил” бүтээлч аяныг 8 байгууллагыг хамруулан зохион байгуулж байна. БСШУС яамны сайдын 118 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн дүрэм” сэдвээр сургалт хийж 12 хүн оролцов. Эрүүл мэндийн төвөөс “Эрүүл шүд” сургалт үзлэг хийж дунд, бэлтгэл бүлгийн 56 хүүхэд оролцов. Тогтвортой хөгжилд Боловсролын байгууллагын удирдлагын оролцоо зөвлөгөөнд 2 хүн оролцож, Сумын Цэцэрлэг, ЕБС-ийн багш ажилчдад сургалт зохион байгуулж 30 хүн хамрагдсан. Иргэдээс багш, ажилчдын ажлын гүйцэтгэлийн талаар асуулгыг хуудсаар авч 54 саналыг авч нэгтгэн холбогдох дүгнэлт хийхэд эцэг эхийн 93,5% сэтгэл ханамж өндөр байна гэсэн үнэлгээ өгсөн байна.Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгтэй Шефийн холбоо тогтоож харилцан туршлага солилцох арга хэмжээ зохион байгуулсан. " Осол гэмтлээс сэргийлэх" үндэсний хөтөлбөрийн хүрээнд " Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу" уриан дор 2019 оны 04 сарын 11-ний өдөр 12:30-13:00 цагийн хооронд СЭМТөвөөс зохион байгуулсан жагсаалд дуу хоолойгоо нэгтгэн оролцлоо.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жилийн хүрээнд самбар, уриалга гарган байршуулж, нийт 119 иргэнд сурталчилгаа мэдээлэл хийв. Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын талаар тогтмол мэдээлэл авах утасны дугаар, хаягийг байршуулав. Иргэдэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй хүргэх, хөдөөгийн айл өрхүүдэд хэсэгчилсэн байдлаар “Хөдөлгөөнт баг”-ийн үйлчилгээг хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Тав. Багт хийгдсэн ажил

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Өтгөн багийн 73 малчин өрхөд ажиллаж хаваржилттай танилцан, төрийн үйлчилгээг хүргэв

МАНЛАЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын Засаг даргын А Захирамж 11, Б Захирамж 2, Сумын Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 2, Сумын Засаг даргын Тамгын газрын даргын Б тушаал 1 тус тус гарсан байна.

Хоёр.Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Архив бичиг хэргийн эрхлэгч, санч-бичээч, НАДАХМэргэжилтэн, ИТХНарийн бичиг, ХЭХАХмэргэжилтэн, Тамгын дарга нар Өмнөговь аймагт мэргэжил тус бүрийнхээ сургалтанд хамрагдаад ирсэн. Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж буй Монголын багш нарын VII их хуралд бага ангийн багш Т.Энхтуул хамт олноо төлөөлөн оролцлоо. Төрөл мэргэжлийн олимпиадын үеэр Монгол хэлний багш Т.Нансалмаа, бага ангийн багш Г.Түвшинбаяр, Түүх нийгмийн багш Т.Очиртуяа,англи хэлний багш Ч.Алдарбаяр нар мэргэжлийнхээ сургалтанд хамрагдсан. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ын гүйцэтгэх захирал-С.Эрдэнэбат ТАХ болон иргэдтэй уулзаж 2019 онд Манлай суманд олгох 50 мян.долларын квотын гэрээг сумын Засаг даргатай байгуулж гарын үсэг зурсан. НАДАХМэргэжилтэн 8-9-р ангийн сурагчдад ХҮЧИРХИЙЛЭЛИЙН ЭСРЭГ сургалт зохион байгуулж 35 сурагч хамрагдсан. Олон улсын эмч нарын баярыг тохиолдуулан Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан хуралд 3 их эмч хамрагдсан. Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сэдэвт АШУҮИС, ЭМГ-тай хамтран зохион байгуулсан сургалтанд 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. “Эмч дуулж байна” өмнөговь аймгийн эрүүл мэндийг газар үүсч байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан тэмцээн болон зөвлөгөөнд 2 их эмч хамрагдахаар явсан байна. ХЭХАХМэргэжилтэн 8-9-р ангийн 35 сурагчдад мэргэжил сонголтын талаар сургалт зохион байгуулсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

ОНХСан болон бусад хөрөнгө оруулалтын ажилд хяналт хийх ИТХ-ын Тэргүүлэгчээр ахлуулсан зөвлөл байгуулсан бөгөөд хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын комиссыг Сумын Засаг даргаар ахлуулан байгуулсан байна. ИТХ-аас баталсан албан байгууллага, аж ахуйн нэгж, зөвлөлүүд, хурлын шийдвэрт хяналт хийх графикийн дагуу "Амьжиргааг дэмжих зөвлөл", "Хүүхдийн төлөө зөвлөл"-ийн 1-р улирлын ажлын тайланг сонсож холбогдох зөвлөмжийг албан бичгээр хүргүүлэв. Иргэдийг төрийн болон салбарын шагналд тодорхойлох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Алтан гадас одонд 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулахаар 3, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулахаар 5 хүнийг тодорхойлж холбогдох газарт уламжиллаа. Төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын жуух бичгээр 3, аймгийн Засаг даргын жуух бичгээр 5, аймгийн Тэргүүний ажилтан цол тэмдгээр 2 хүнийг тус тус тодорхойлж шагнуулсан байна. Дэлхийн усны өдрийг ЭМТ-тэй хамтран зохион байгуулсан. Уг өдрийг угтуулан ЕБС-ийн сурагчдын бага ангийн сурагчдын дунд “Ус-амьдрал” сэдэвт гар зургийн уралдаан-84 сурагч , ахлах ангийн сурагчдын дунд АХА тэмцээн-132 сурагч , иргэдийн дунд “Цэнгэг ус-тэгш хүртээмж” уриан дор гар бөмбөгийн тэмцээнд 12 багийн 72 тамирчин оролцсон. Мөн бага ангийн сурагчдын дунд “Усаа хайрлая” сургалтыг 84 сурагчдад зохион байгуулсан. “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын анхдугаар зөвлөгөөн”-нд зориулж нийт төрийн албан хаагчдын дунд спортын 6 төрлөөр тэмцээн уралдаануудыг зохион байгуулсан. Хөдөө аж ахуй үйлдвэржилтийн жил, Соёлыг дэмжих жил, Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн нээлтээр аймгийн ХЖТеатрын уран бүтээлчдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь урьж ирүүлэн албан хаагчид, малчид, иргэдэд үнэ төлбөргүй тоглолт сонирхууллаа.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Удирдлагын академийн багш, доктор, Шинэ эхлэл-шинэ итгэл ТББ-н тэргүүн Баасанхүүгийн Гансүх-ийг урьж нийт төрийн албан хаагчид болон ард иргэддээ "Хувь хүний хөгжил", "Төрийн албан хаагчийг чадавхижуулах нь" лекцийг уншуулсан. Нийт 150-аад ард иргэд болон ТАХ-д хамрагдсан. “ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН САХИЛГА ХАРИУЦЛАГЫН АНХДУГААР ЗӨВЛӨГӨӨН”-ЫГ зохион байгуулж төсөвт 8 байгууллагын 108 төрийн албан хаагчид буюу нийт ТАХ-ын 85% хамрагдсан. Үүний үр дүнд нийт ТАХ-даа сахилга хариуцлагын зөвлөгөөний шийдвэр дүгнэлтийг

үндэслэн төсөвт байгууллагууддаа зөвлөгөөнөөс гарсан ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлсэн. Манлай сумын сургуулийн /хуучин/ барилгыг "ХАНБОГД ИНДАСТРИ" ХХК их засвар хийж оёдлын үйлдвэр байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус оёдлын үйлдвэр нь гэрээр байсан 22 эмэгтэйг оёдол, эсгүүрийн сургалтад компанийн зардлаар сургаж "Оюутолгой" ХХК-ний гүний уурхайд нийлүүлэгдэх 1 удаагийн ус, тосны хамгаалалтын хувцасыг нийлүүлэхээр үйлдвэрлэж байна. Өдөрт 190 орчим эсгүүр бэлтгэж, 3 удаагийн дамжилгаар 300 хамгаалалтын хувцасыг оёж бэлэн болгодог үйлдвэр юм.

Тав. Багт хийгдсэн ажил

Гэрийн эргэлтийн үзлэгийг нэмэгдүүлэн багийн эмч, их эмч нар 0-5 насны хүүхэд, ахмад настны эргэлтийг тогтмол хийж байгаа. Энэ сарын товлолт вакциныг томуугийн дэгдэлт намжсантай холбоотой амбулатороор хийж байна. 2019 оны эрт илрүүлэгийн үзлэгийг төлөвлөгөөнийхөө дагуу тогтмол үзлэг хийж ажиллаж байна. Багийн эмч нар багийнхаа малчин айл өрхүүдээр очиж эрүүл мэндийн үзлэг, мэдээ мэдээлэл хүргэхээр явсан байна. Багийн дарга нар, малын эмч нар малчин айл өрхүүдээрээ явж хаваржилтийн байдалтай танилцаж, ОНХСангаар хийгдэх ажлын санал авах маягт бөглүүлэхээр явсан.

НОЁН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Засаг даргын Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын явуулын үзлэгийг 2019 онд зохион байгуулах тухай, Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах комисс байгуулах тухай, Гэрээт ажлын санхүүжилт олгох тухай, Газар олгох тухай, Газар эзэмших эрх шилжүүлэх тухай, Газар эзэмших эрх хүчингүй болгох тухай, Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах зэрэг нийт 7 захирамж гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

4 дүгээр сарын 3-нд Статистик төрийн сангийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ төрийн сангийн сургалтанд хамрагдсан. Иргэний Улсын багц хуулийн сургалтанд Улсын бүртгэгч У.Нандинцэцэг хамрагдсан. Бүх төрийн албан хаагчид Иргэн төвтэй төрийн үйлчилгээ, сахилга хариуцлагын зөвлөгөөнд 4 дүгээр сарын 08-ны өдөр хамрагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Засгийн газрын 2018 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд Иргэн төвтэй төрийн үйлчилгээ, Сахилга хариуцлагын зөвлөгөөний нээлтийн үйл ажиллагаа 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулагдаж бүх албан байгууллагууд орлцсон. Мөн Иргэн төвтэй төрийн үйлчилгээ, Хөдөө аж ахуй үйлвэржилтийн жил, Соёлыг дэмжих жилийн нээлтийн үйл ажиллагааг Засаг дарга Б.Батболд үг хэлж нээсэн. Уг арга хэмжээнд салбартаа амжилттай ажиллаж байгаа иргэдийг шагнаж урамшууллаа. Аймгийн Хүнс Хөдөө Аж ахуйн шагналаар Д.Бурмаа, Ц.Тунгалаг, Т.Мягмар нар шагнагдсан.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

2019 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага 04 сарын 16-ны өдөр зохион байгуулагдлаа. Соёл хүмүүжлийн ажлын хүрээнд Ерөнхий боловсролын Сургуулиас Соёлын өвийг дээдлэх, өвлүүлэх зорилгоор “Сайхан бичигтэй Ноёнчууд” арга хэмжээг зохион байгуулж 1-3 дугаар байр эзлүүлэн шагнаж урамшуулсан. ХАБЭА-н сарын аяны хүрээнд төлөвлөгөө гарган бүх албан байгууллага, аж ахуй нэгжүүд хамрагдаж байна. 7 хоногт 1 удаа албан хаагчид мэдээлэл, сургалт зохион байгуулж ажиллаж байна. Хөдөлмөр зуучлалын программд ажил идэвхитэй хайж байгаа 24 иргэн байна. Ажил хайгчийн бүртгэлд шинээр 5 иргэн бүртгүүлсэн. 5 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Шинээр 24 түр ажлын байр бий болсон. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид- 20 иргэнд 2908.8 мян төг, байнгын асаргаатай- 31 иргэнд 2170.0 мян төг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амжиргаа дэмжих тэтгэмж 5 хүүхэд-775.0 мян төг, жирэмсэний тэтгэмж- 10 эхэд 400.0 мян төг, Цалинтай ээж

хөтөлбөр 64 эхэд-3160.0 мян төг, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ 6 өрх 2240.0 мян төг, Ахмадын шүдний хөнгөлөлт 1 ахмад- 65.0мян төг, Насны хишиг 53 ахмад 5290.0 мян төг Нийт 17008.8 мян төгрөгийн олголт хийгдсэн. 2019 оны 01 дүгээр сараас хойш өрхийн амжиргааны судалгаанд хамрагдсан нийт 10 өрхийн мэдээллийг нягтлан баталгаажуулсан. 2019 оны 2-3 дугаар саруудад шинээр төрсөн 6 хүүхдийн өргөдөл хүлээн авч өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулсан. 4 сарын 22-ны байдлаар сумын хэмжээнд ботго 645, унага 1, хурга 1985, ишиг 13444 нийт 16075 төл хорогдолгүй 100% бойжиж байна. Том малын хорогдолгүй тарган сайхан хаваржиж байна. Жимс жимсгэнэ тариалах сонирхолтой 2 иргэнийг Ногоон хэрмийн талбайн сургалтад хамруулсан.

НОМГОН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын Засаг даргын “А” захирамж 10 гарсан байна. Үүнд: Хаягдал ус зайлуулах цэг тогтоох тухай, Сумын мал тооллогын түр товчоо байгуулах тухай, Хармагтай багийн мал тооллогын түр товчоо байгуулах тухай, Төхөм багийн мал тооллогын түр товчоо байгуулах тухай, Дэрсэнэ ус багийн мал тооллогын түр товчоо байгуулах тухай, Эмгэн булаг багийн мал тооллогын түр товчоо байгуулах тухай, Богт багийн мал тооллогын түр товчоо байгуулах тухай, Эгшиглэнт говь 2019 яруу найргийн наадамд зардал гаргах тухай, Ажлын хэсэг байгуулах 2 захирамж гарсан байна. Тамгын газрын даргын “А” тушаал 6 гарсан байна. Үүнд: Үнэлгээний хороо байгуулах тухай, Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн дүрмийг батлах тухай, Д.Одгэрэлд зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Ц.Энхтүвшинд сахилгын хариуцлага тооцох тухай, Үнэлгээний хороо байгуулах тухай.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Тамгын газрын албан хаагчдын болон албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарын “Шуурхай хурал”-ыг 1 удаа хуралдаж, удирдлагуудаас цаг үеийн мэдээлэл өгч, үйл ажиллагаатай нь танилцаж, санал солилцлоо.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Засаг даргын Тамгын газар: УИХ-ын гишүүн Л.Энхболд орон нутагт ажиллаж иргэд, малчидтай уулзалт зохион байгуулж, сум, баг, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, хөдөөгийн өрхүүдээр явж хаваржилтын байдалтай танилцлаа. “Халх голын ялалтын 80 жилийн ой”-н нээлтийн арга хэмжээ зохион байгуулагдлаа. Шинээр төрсөн 16 хүүхэд, овог, нэр өөрчлөлт 1, гэрлэлт 1, нас баралт 2, шилжиж ирсэн 9 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Хармагтай багийн нутагт байрлах Булаг сүүж ХХК-ний үйл ажиллагаа эхлэх гэж байгаатай холбогдуулан уурхайн талбайд хийгдэж байгаа ажлын явц болон байгаль орчны чиглэлээр бүрдүүлэх баримт бичгийн бүрдүүлэлтэнд хяналт шалгалтын хийж, холбогдох заавар зөвөлгөөг өгч ажиллалаа. Одоогийн байдлаар 23 иргэн ажил хайгч бүртгэлд бүртгүүлж, 1 иргэнийг бүр, 6 иргэнийг түр ажлын байранд зуучилсан байна.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

“Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын зөвлөгөөн”-д нийт 62 албан хаагч оролцож, “Дэвжээ”, “АХА”, Гар бөмбөгийн тэмцээн, цэнгүүнийг зохион байгууллаа. 2019 оныг “Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн жил” болгосонтой холбогдуудан иргэдэд сурталчлах самбар, гарын авлага хийж иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Монгол Ви Ай нет Төрийн бус байгууллагаас зохион байгуулсан Малын эмийн зохистой хэрэглээний талаар сургалтанд МЭТасаг, МЭҮНэгжүүдтэй хамтран 103 малчинг хамруулсан. Мөн Мал эмнэлгийн тусламж үйлчилгээг 545 малчин өрхийн 42660 төл малыг шөвөг яраас урьдчилан сэргийлэх витаминжуулалтад хамруулж мал,амьтны эрүүл мэндийн

тухай хуулийн мэдээлэл малчдад хүргэж ажилласан. Сумын удирдлагууд, ЗДТГазрын албан хаагчид, багийн Засаг дарга нар, багийн эмч нарын бүрэлдэхүүнтэй 7 ажлын хэсэг малчин өрхүүдээр явж хаваржилтын байдалтай танилцаж, иргэдийн санал бодлыг сонсож, аймаг, сумын цаг үеийн мэдээллийг хүргэж, Өрх гэр бүлийн дэвтрийн бүртгэлийг хийлээ.

Тав. Багт хийгдсэн ажил

Багийн эмч нар багийн малчин өрхөөр баг тус бүртээ явж, урьдчилан сэргийлэх үзлэг хийж, малын өвчин галзуу, хачигт халдвар, бэтэг, хуванцар савны хэрэглээний талаар зөвлөгөө зөвлөмж өгч, 6 төрлийн нийт 546 ширхэг гарын авлага тараасан. Нутгийн хэмжээгээр хаваржилт боломжтой байна.

ХҮРМЭН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Зардал гаргах тухай, урамшуулал олгох тухай, зөвлөл байгуулах тухай, эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай, газар эзэмшүүлэх тухай, зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай нийт 9 захирамж, ажлаас чөлөөлөх тухай, ажилд томилох тухай, комисс томилох тухай нийт 5 тушаал, 14 албан бичиг гарсан байна.

Хоёр.Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас 2019 онд халамж үйлчилгээний чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөрүүд, нийгмийн халамжийн талаар сургалт явуулж 56 хүн хамрагдлаа. Аймгийн Шүүхийн тамгын газраас шүүхийн иргэний төлөөлөл, тэдний эрх үүргийн талаар сургалт явуулж 72 хүн хамрагдлаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2 удаа хийж Зөвлөл байгуулах тухай, Ан агнуурын бүс тогтоох тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. СЗДТГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг и-оффисд бүрэн оруулсан. Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрийг хяналтанд авч и-оффисд бүртгэж байна. Судалгаа, хариутай бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтүүдийг тухай бүр гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Хүрмэн сумын Тулга багийн нутаг Их Аргалант, Бага Аргалант, Жанжин багийн нутаг Улаан дэл уул орчмын газруудад Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах эзэмших талаар иргэдийн нөхөрлөлийг сумын ИТХТэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, тогтоол гаргуулан БОАЖЯаманд уламжиллаа. Хүрмэн, Баяндалайн хилийн бүс орчимд иргэдийн бэлчээр, усны маргаан гарсныг 2 сумын холбогдох удирдлага, мэргэжилтнүүд оролцон газар дээр нь маргааныг шийдвэрлэсэн. БОХУБайцаагчын 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт эргүүлийн удирдамж гарган сумын Засаг даргаар батлуулж Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа “Альшаа хайрхан” ХХК-ны ААНэгжийн газарт үзлэг хийж нөхөн сэргээлтийг хүлээн авсан. Хууль бусаар алт олборлож байна гэсэн мэдээлэлийн дагуу Жанжин багийн нутаг Чавганцын хар, Хашаат зэрэг газруудад эргүүл хяналтыг нийт 457км газар нутагт хяналт шалгалтыг хийхэд зөрчил илрээгүй. Хаяаагийн элс, Гүн заг зэрэг газруудад Цагаан гоёо түүж байгаа эсэхэд хяналт шалгалтыг давхар хийсэн болно. Аймгийн Засаг даргын орлогч даргын албан тоот, удирдамжын дагуу “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг зөрчил ба оролцогч талууд” сэдэвт 2 өдрийн сургалтанд хамрагдлаа. Тус сургалтаар ЦЕГазар, ПЕГазар, МХЕГазар, БОАЖЯам, ХХААЯамнаас мэргэжлийн багш, докторууд оролцон сургалт ярилцлагыг зохион байгуулсан. Иргэнд шинээр газар эзэмшүүлэх, Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх гэсэн сумын Засаг даргын 2 захирамж гаргасан. Газрын мэдээлэлийн сангийн Лэнд менежер программд 15 газар эзэмших эрхийн нөхөн бүрдүүлэлт хийж Улсын бүртгэлийн газар луу

“15 Г” дугаар цахимаар захиалаад байна. Хүрмэн, Баяндалай сумдуудын хилийн цэс газарт 2 иргэний хооронд үүссэн ус цэг, хаваржааны газрын маргаан гарсаныг тус сумдуудын Засаг дарга, Газрын даамалууд газар дээр нь ажиллан маргааныг шийдвэрлэсэн.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулагдсан “Шинэлэг ажил”

Халх голын түүхэн ялалтын 80 жилийг ойг угтаж өвөг дээдэс, ахмад дайчдын баатарлаг гавьяаг үр хойчдоо таниулан үлдээх зорилгоор байгууллага, нэгжүүдийн дунд БҮТЭЭЛЧ АЯН-ыг зарлан туг, домыг 4 сарын 8-наас эхлэн аялуулж байна.

ЦОГТ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын Засаг даргын А захирамж 20, Б захирамж 2 буюу нийт 22 захирамж төлөвлөгдөн гарсан байна. Бүсчилсэн хөгжлийн ажлын хэсэг байгуулах тухай 1, Хөрөнгө зарцуулах тухай 7, Газар зохион байгуулалттай холбоотой 8 захирамжуудыг батлан мөрдөн ажиллаж байна. ЗДТГазрын даргын А тушаал 4, Б тушаал 1 батлагдсан байна. Ажлын хэсэг байгуулах тухай 3, Хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай тушаалуудыг тус тус батлаж мөрдөн ажиллаж байна

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

“Эрхзүйн хөтөч бэлтгэх” сургалтанд ИТХ-ын Нарийн бичгийн дарга П.Хүүхэн, Нийгмийн асуудал, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Одонцэцэг нар сургалтанд хамрагдлаа. Засаг дарга Э.Чойжилсүрэн, ЗДТГ-ын дарга А.Нарандэлгэр “Орон нутгийн хамгаалалтад бидний оролцоо” сургалтанд хамрагдлаа. Захиргааны ерөнхий хуулийн сургалт арга хэмжээнд оролцсон. Архив, бичиг хэргийг эрхлэгч Т.Будшүрэн, ЕБС-ын бичиг хэрэг Ц.Хандсүрэн нар Архивын сургалтад хамрагдсан. “Шинэ эхлэл – Шинэ итгэл” ТББ-ын сургалтын албанаас зохион байгуулсан “Хувь хүний хөгжил” сэдэвт Б.Гансүх лекторын сургалтанд 99 иргэн хамрагдаж өөртөө хөрөнгө оруулалт хийж гэрчилгээгээ гардан авлаа. Тус сургалтын төлбөр болох 1 сая төгрөгийг сумын ЗДТГ-аас гаргаж иргэдээ өргөнөөр хамрууллаа. Тогтвортой амжиргаа3 төслийн сургалтанд 10 албан хаагч хамрагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил, Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн жил, Соёлыг дэмжих жилийн нээлтийн арга хэмжээг 2019.04.13-ны өдөр зохион байгуулж 5 байгууллага, 5 хорооллын иргэд хөдөлмөрчид идэвхтэй оролцлоо. Тус арга хэмжээний хүрээнд Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны тайлан, 2019 оны хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулан иргэдэд тараахаас гадна, иргэдээс 2020 онд ОНХСангаар хийгдэх ажлын саналыг авч ажиллаа. Албан хаагчид 1 дүгээр улирлын тайлангаа бүх мэргэжилтнүүд хамт олондоо тайлагнасан. Санхүүгийн албанаас Байгууллагын дарга, нягтлан, няравуудад санхүүгийн талаар дотоодын сургалтыг зохион байгуулсан. Сумын төвийн айл өрхүүдээр явж цаг үеийн мэдээ мэдээлэл өгч, судалгаа авч ажилласан бөгөөд Дэнжийн хорооллыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж ажилласан. Өмнөговь аймаг дахь Шүүхийн тамгын газраас Иргэдэд мэдээлэл сургалтыг зохион байгуулсан. Сумын Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн нэгж, Монгол Би И Ти Нэт ТББ-тай хамтран малчдад зориулан зохион байгуулсан “Малын эмийн зохистой хэрэглээ” сэдэвт сургалтанд 32 малчин хамрагдлаа. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2 удаагийн хуралдаанд сумын Засаг дарга, ХАА-н тасгийн мэргэжилтэн нар оролцлоо. Цогт-Овоогийн улаан ямааны омог батлуулах судалгааны ажлын хүрээнд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний

хүрээлэнгийн доктор ямаа судлаач Г.Сувдаа 8 өрхөөр явж цөм сүргийн 3500 малд үзлэг, ангилалт хийсэн.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 30.000\$-ын хөрөнгө оруулалт хийхээр боллоо. 2018 онд хийсэн ажлаа дүгнэж, 2019 онд дахин 30000 \$-ын хөрөнгө оруулалт хийхээр талууд хамтран ажиллах гэрээ байгууллаа. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил", "ХАА үйлдвэржилтийг дэмжих жил", "Соёлыг дэмжих" жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Сумын төвийн төсөвт байгууллагууд, Ардын авьяастнууд, Малчид, Хорооллуудын иргэдийг оролцуулан өргөн дэлгэр арга хэмжээг зохион байгууллаа. Халх голын түүхт 80 жилийн ойн нэрэмжит "ТУСГААР ТОГТНОЛ, ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ХӨГЖИЛ ДЭВШИЛ" бүтээлч аяны үйл ажиллагааг 2019 оны 04-р сарын 12-ны өдрөөс ЕБСургууль, Малчин хорооллоос эхлүүллээ. 2019-06-14-нд дуусна.

ЦОГТЦЭЦИЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 1 удаа хуралдаж, 5 тогтоол гарав. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны дарга Ц.Ууганцэцэгийг ажлаас чөлөөлөх тухай, Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах сум орон нутгийн саналыг хэлэлцэх тухай, “Эмэгтэйчүүдийн оролцоо-Хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан саналыг хэлэлцэх тухай, Сумын ИТХ-ын дэргэд “Тогтвортой хөгжил-Түншлэл” зөвлөл байгуулах тухай, Шагналд тодорхойлох тухай, сумын Засаг даргын А захирамж 20, Б захирамж 2, сумын Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 2 , Б тушаал 4 тус бүр гарсан байна.

Хоёр.Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

“Тогтвортой амжиргаа-3” төслийн сургалт Даланзадгад суманд зохион байгуулагдаж оролцлоо. Газар тариалан эрхлэгчдийн сумын зөвлөгөөн зохион байгуулсан. Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн арга хэмжээ, газар тариалан эрхлэгчдийн улсын зөвлөгөөнд Газар тариалан хариуцсан мэргэжилтэн оролцсон. Давсны хэрэглээг бууруулах стратегийн хүрээнд иргэдэд гарын авлага хүргэж, ахмадуудад мэдээлэл, сургалт хийсэн. Хөдөлгөөнт багаар хөдөөгүүр малчидтай уулзах, мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эргэн төллөлтийг сайжруулах зорилгоор 6 зээлдэгчдийг харьяа шүүхэд нэхэмжилсэн. Гялгар уутны хэрэглээг бууруулах зорилгоор худалдааны газруудад мэдээлэл, зөвлөмж хүргэж уриалга гаргасан. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг тохирлын үнэлгээнд хамруулж, жин хэмжүүрийг баталгаажуулсан. Тариалан эрхлэгчдийг хүнсний ногооны үр, бордоогоор хангасан. Бүх нийтийн хог цэвэрлэгээг 2019.04.12-13 хийсэн. Байгаль орчны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хэрхэн шийдвэрлэх арга зүй, гэмт хэрэг зөрчлийн ялгаа, шалган шийдвэрлэх ажилд ямар оролцоог хангах, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийг хэрхэн хамгаалах багц хуулийн сургалт 2018.04.18-19-ны өдрүүдэд зохион байгуулсан. Өмнөговь аймгийн БОАЖГ-ын Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн “Ус ашиглах гэрээ” байгуулах 2019.04.15-2019.04.17 айл зохион байгууллаа. Улсын бүртгэлийн талаар “ Хүүхэд үрчлүүлэх ” тухай Сумын Засаг даргын А захирамж 1 гарсан байна.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Сумын төвийн нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулагдав. Тус ажлын хүрээнд айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллагууд идэвхтэй оролцлоо. Цогтцэций сумын "Их Шанх"даамны клубын тамирчид Улаанбаатар хотноо болсон "Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах даам"-ны тэмцээнд ажилттай оролцож ирсэн байна. Тухайлвал Саруулын Болор Хошой мөнгө, Батзоригийн Тэмүүлэн мөнгө, хүрэл, Норовсүрэнгийн Лхагвадолгор хүрэл медалиудыг тус тус хүртсэн амжилттай оролцжээ. Тус үйл ажиллагаанд "Клин Энержи Ази" ХХК дэмжлэг үзүүлэн хамтран ажиллав. Дотрын эмч

Ц.Баяржаргал, бага эмч О.Ганцэцэг нар багуудаар явж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, малчдад витаминжуулалт өгч үйлчилсэн. 04 сарын 12, 13 –нд байгууллагаараа орчны цэвэрлэгээ болон Цагаан-Овоо багийн иргэдийг хээрийн цэвэрлэгээнд гаргалаа.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Сумын ИТХ-ын дарга төлөөлөгчид нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй БНХАУ-ын Гуаньжу хотод зохион байгуулагдсан CANTON FAIR 125 дахь үзэсгэлэн худалдаанд оролцож, Жижиг дунд үйлдвэрлэл, техник тоног төхөөрөмжийн туршлага судалж ирэв. Нүдний болорын цайралттай хүмүүст Улаан загалмайн шугамаар БНХАУ-ын Ганц мод боомтод үнэ төлбөргүй хагалгаа хийгдэхээр болж сумын иргэдийг үзлэгт хамруулав. Үндсэн хуулийн болон Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн төсөлд ИТХ-ын төлөөлөгч, багийн засаг дарга, ЗДТГ-ын мэргэжилтэнүүдээс санал авч нэгтгэн аймгийн ИТХ-д хүргүүлэв. Шинээр батлагдсан Улсын бүртгэлийн багц хуулийн талаарх мэдээ мэдээллийг Цагдаагийн хэлтэс, Цог-Өрнөх ОНӨААТҮГазар, Онцгой байдлын 44-р ангийн албан хаагчид, 6-р цэцэрлэгийн албан хаагчид, Ахмадууд нийт 98 иргэнд мэдээллийг хүргэн ажилласан. Цогтцэций сумын хэмжээнд зохион байгуулсан “Нийтийн хог цэвэрлэгээ”-ний ажилд байгууллагын 7 хүн оролцож “Баруун суу” хорооллын айл өрхүүдийг хог цэвэрлэгээнд гаргаж, хяналт тавьж , бүртгэл хийсэн. Мөн “Нийгмийн даатгалын тасаг”-тай хамтран хуваарилагдсан хээрийн талбайг цэвэрлэсэн.